

## Монгол Улс дахь улс төрийн хошуучлагчийн талаарх олон нийтийн мэдлэг

**Батхишигийн Энхчимэг, магистр**

*Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн*

*Улаанбаатар, Монгол Улс, [enkhchimeg\\_b@mas.ac.mn](mailto:enkhchimeg_b@mas.ac.mn);*

<https://orcid.org/0009-0004-2180-972X>

### Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-20

Published : 2024-12-20

### Түлхүүр үгс

*хошуучлал, улс төр,  
нийгмийн өөрчлөлт,  
нийгмийн хөгжил,  
хувьсал,  
шинэчлэл,  
нийгэм*

**Хураангуй:** Монгол Улсад хошуучлал байна уу, хэн хошуучилж байна, аль салбарт хошуучлал илүү байна, хошуучлал хэрхэн өрнөж буй болон хэнийг хошуучлагч гэж харж байна гэдэгт онцгой ач холбогдол өгч “Улс төрийн харилцаанд улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө” сэдэвт судалгааны үр дүнд үндэслэх юм. Улс төрийн хошуучлал хийгээд хошуучлагч нь маш өргөн цар хүрээтэй, иргэд олон нийтэд үгний утгаас эхлээд ойлгогдоход бэрх юм. Энэ утгаар тус судалгаагаар иргэд олон нийтийн хошуучлалын талаарх төсөөлөл хийгээд ерөнхий дүр төрх, чадваруудын талаар тусган оруулав. Иргэдийн дийлэнх масс нь Монгол улсад улс төрийн хошуучлалын талаарх төсөөлөл, ойлголт иргэд олон нийт хошуучлалын талаарх ерөнхий нэгдмэл ойлголтод хүрээгүй байна. улс төрийн хошуучлалд нас, хүйс, боловсрол, шашин, ажил мэргэжил зэрэг нийгмийн хүчин зүйлд хэрхэн нөлөөлж буйг мөнхүү тусган оруулсан болно. Судлаачдын үзсэн дээрх үзэл баримтлал, тодорхойлолтоос харахад *манлайлах, хошуучлах, удирдах* гэсэн ойлголтууд нь нэгэн ижил утгатай ойлголт биш гэдгийг илтгэнэ. Угтаа манлайлна гэдэг нь *нөлөө үзүүлнэ* гэсэн үг, удирдана гэдэг нь *захирах, захирагдах ёс* юм. Энэ агуулгаараа *манлайлна, удирдана* гэсэн ойлголтыг салангид үзэж хэрхэвч болохгүй. Удирдагч хүн гэдэг бол өөрийн ямар нэгэн шинж, чадвараар олон нийтийг өөртөө татаж, басхүү нөлөөлж байдаг. Тодорхой бүлгийн манлайлагчид ч гэсэн эрх мэдэлгүйгээр олон нийтийн ашиг сонирхлыг нэгтгэн илэрхийлж, нийгэмд байр сууриа хэзээ ч олж чадахгүй учраас эрх мэдэл рүү тэмүүлэх нь зүй ёсны хэрэг гэж үзэж болох юм. Иймээс хүн тодорхой хэмжээний эрхтэй байж л манлайлна гэсэн үг. Эрх гэдэг нь нэг хүний зан байдал нөгөө хүний зан байдалд нөлөөлөх чадвар юм. Байгууллагын болон бүлгийн гишүүдэд нөлөөлөх манлайлагчийн чадвар нь бүлэг ба хувь хүмүүс өмнөө тавьсан зорилгодоо хүрэх бүх арга замыг тодорхойлоход тусалдаг.

**Keywords**  
*leadership, politics, social change, social development, evolution, reform, society*

## Public knowledge about political leader in Mongolia

**Enkhchimeg Batkhishig** (MA)

*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences*

*Ulaanbaatar, Mongolia, [enkhchimeg\\_b@mas.ac.mn](mailto:enkhchimeg_b@mas.ac.mn); <https://orcid.org/0009-0004-2180-972X>*

© The Author(s), 2024



**Abstract:** This paper aims to clarify how Mongolian leaders understand and know the word and translate it into scientific information. In general, political leadership is defined as the power of society to make decisions and its influence, participation and implementation. According to J. Blandel and R. Tucker believe that political leadership includes governance and power relations. Researchers found that the concepts of leadership, command and management were not synonymous, that leadership meant influence, and that management meant command and subordination. In this respect, the concept of leadership and management should not be seen separately. Leaders are responsible for attracting the public and influencing their characteristics and abilities. Some groups fight power because they cannot represent the interests of people without power and find their place in society, so it is natural for them to fight for power. The basic scientific research project of the Department of Political and Legal Studies of the Mongolian Academy of Sciences, Institute of Philosophy, focuses on the role and impact of political leadership on the perception, knowledge and behaviour of citizens. We analyze the quantitative and qualitative methods of social research. According to the survey results, Mongolian politicians have not yet reached a consistent understanding of public opinion and opinions. Further research will look at how different citizens are perceived by leaders, what influences are influenced by them, and how different people are perceived by leaders in other countries.

### I. Оршил

Улс төрийн хошуучлалын талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, төлөвшил хандлагыг энэхүү өгүүлэлээр дамжуулан илэрхийлэх зорилготой бөгөөд энэ талаар хийгдсэн социологийн судалгааны үр дүнд үндэс болгов. Тус судалгааг гүйцэтгэхдээ нийгэм-улс төрийн хөгжлийн талаарх төсөөлөл, мэдлэг, ойлголтыг анкет-сурвалжилгын аргаар явуулан шинжилсний үр дүнд “Монголчуудын улс төрийн хошуучлалын талаарх мэдлэг, ойлголт түүнд гарсан өөрчлөлт”-ийн талаар гүйцэтгэсэн судалгааны хүрээнд гарсан үр дүнд тулгуурлан бичихэд гол зорилго оршино.

Энэхүү өгүүлэлд судалгаагаар гарсан үр дүнгүүдэд социологийн шинжилгээнээс сегмент болон

харьцуулсан, дан тоололт хийн ерөнхий дүнг тус өгүүлэлд оруулсан болно. “Монголчуудын улс төрийн хошуучлалын талаарх мэдлэг ойлголт” хэмээх өгүүлэлд дурдсан нөхцөл байдал өнөө цагт хэрхэн хувьсан өөрчлөгдөж буй талаар судалгааны үр дүнд тулгуурлан харьцуулан жишсэн болно. Судалгаанаас гарсан гол үр дүнгээс толилуулахад хошуучлагч гэдэг үгийн ойлголт тааруу, улс төрд хошуучлах улс төрчгүй, хошуучлалтай салбар бага, хошуучлагчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг хэлж чадаж байгаа боловч Монгол Улсад гарч ирээсэй гэж хүсэх хошуучлагчид тавих шалгуур нь өндөртэй байв. Үе үеийн нийгэмд нэр хүнд, хийж бүтээсэн ажил, алдар гавьяагаараа алдаршсан төрийн тэргүүн, ардын баатруудыг нэрлэж

тэдэнтэй адилтгаж нэг бүрчлэн хардаг гэх мэтчилэн үр дүнгүүд гарсан. Улс төрийн хошуучлалын талаар олон эрдэмтэн, судлаач нар судалж буй хэдий ч бид энэ удаад нэлээн өргөн хүрээнд судлахаар олон хүнийг хамруулж, үр дүнг олон нийтэд хүргэж нэр томьёоллыг түгээн дэлгэрүүлэх нь бидний энэ удаагийн судалгааны нэг гол шинэлэг тал болсон юм. Харин сул талын хувьд иргэд, олон нийт “хошуучлагч” гэж асуух тэр мөчид тус үгний утга, мөн чанарыг ойлгохгүй, өөрсдийн төсөөллөөр хариулт өгч байв. Юуны өмнө улс төрийн хошуучлагч гэж хэнийг хэлж бас ойлгох вэ? гэдгийг судалгааны өгүүллийн гол асуулт болгон дэвшүүлсэн юм. Энэ асуултад шууд хариулт авах боломжгүй учраас тухайн судалгааны эхлэлээс төгсгөл хүртэл түүний хариултыг бүрэн олохыг хичээв.

Энэхүү өгүүллийн эхлэлд тухайн асуултад хариулахдаа юуны өмнө “хошуучлал” гэх үгийг монгол хэлний тайлбар толь бичигт хэрхэн тусган тайлбарласнаас эхлэх нь зүйтэй болов уу. Монгол хэлнээ *leadership* хэмээх үгийг манлайлал, хошуучлал гэсэн хоёр янзаар буулган утгачилж байна. Цольд хэл шинжээч Я.Цэвэлийн 1966 онд Улаанбаатар хотноо эрхлэн гаргаж, Х.Лувсанбалдангийн шүүдэглэснээр олон нийтийн хүртээл болсон «*Монгол хэлний товч тайлбар толь*»-д манлайлагч, манлайлах гэдгийг «*манлайлах үйлийн нэр: манлай болох, тэргүүлэх: дээд, сайн, тэргүүн зэрэгт тооцогдох*», *хошууч, хошуучлах гэдгийг “хамгийн түрүүнд явагч, бусдыг дагуулагч: цэргийн албан хаагчдад олгох нэгэн зүйлийн цол: магнайн цэрэг: хошууч болох, тэргүүлэх*» (Цэвэл Я. 1966, 331, 702)

гэх утгаар тайлбарлагддаг. Судалгааны түвшинд авч үзвэл, манай өнөөгийн улс төрийн судалгаанд хошуучлал, хошуучлагч Б.Баярсайханы эрхлэн хэвлүүлсэн «*Монгол хэлний тайлбар толь*» -д Я.Цэвэлийн гаргасантай төстэй тайлбарыг хийжээ. (Баярсайхан Б. 2011, 684, 1489) Мөн “удирдагчийн манлайлал гэсэн нэмэлт тайлбарыг оруулсан нь угтаа манлайлал гэсэн үгийг удирдахуйн ухаанд өргөн дэлгэр хэрэглэж байгааг хүлээн зөвшөөрснийг (Отгонбаяр Н. 2019) илтгэнэ. Англи хэлнээс “*Leader*” гэдэг үг нь Монгол хэл рүү хошуучлагч, манлайлагч гэж орчуулагдаж байгаа юм. Энэ мэтчилэн эрдэмтэн, судлаач нар хошуучлалыг олон талаас нь өөр өөрсдийн үзэл баримтлалаар тайлбарлаж байна. (ХЗХ., ШУА 2008, 20) гэж үзэж болохоор. Жишээлбэл судлаач Эдингер «*Манлайлал гэдэг нь нөлөө, нэр хүнд, эрх мэдэл ба бусдыг хянах явдал юм. Гэвч нөлөө бүр манлайлал биш*» гэсэн бол Л.Даунтон «*Манлайлал гэдэг нь бүлгийн бүх гишүүдийг эсвэл заримыг нь хамтран ажиллахад нь чиглүүлэх ба зохион байгуулах хувь хүний чадвараар тодорхойлогддог бөгөөд түүний нийгэмд эзлэх байр суурь*» хэмээжээ. Судлаач Файли, Хаус, Керр нар хошуучлалыг «*Удирдлага гэдэг нь удирдлага дор байгаа хүн нь урьдчилан өгсөн албан ёсны үүрэг даалгаврыг гүйцэтгэхэд хүргэдэг, тодорхой бодлогыг боловсруулж шийдвэрлэдэг оюуны хөдөлмөр юм, харин манлайлал гэдэг нь бүлгийн нэг гишүүн бусад гишүүдэд нөлөөлөх үйл явц*» гэдэг талаас нь авч үзжээ. Харин Питер Друкер «*Манлайлал гэдэг нь хүний үйл ажиллагааны үр ашгийг өндөр түвшинд хүргэх, хүнийг хязгаарлагдмал хүрээнээс гаргах,*

хувь хүнийг төлөвшүүлэх чадвар» (Наранцэцэг П. 2020) хэмээн тус тус тодорхойлсон нь бий.

## II. Судалгааны арга зүй

Тус судалгааг 3 бүлэг 52 асуулттайгаар социологийн тоон болон чанарын судалгааг явуулсан. Судалгааны түүвэрлэлтийг социологийн энгийн санамсаргүй түүврийн аргыг ашиглахын зэрэгцээ үндэсний статистикийн ([www.1212.mn/mn](http://www.1212.mn/mn)) сайтын мэдээнд тулгуурлан түүврийг тооцсон болно. Мөн хөдөө орон нутгийн 21-ээс 5 аймгийг сонгохдоо нөхцөл байдлын судалгаан дээр суурилан гүйцэтгэсэн. Тус судалгааг сорилын судалгаанд түшиглэн дахин засвар хийн боловсруулж Улаанбаатар хотоос 516, хөдөө орон нутгаас 535 нийт 1051 респондент хамруулан мэдээлэл цуглуулж ажиллав. Цуглуулсан мэдээллийг SPSS-27 программд шивж, боловсруулалт хийсэн. Улаанбаатар хот болон түүвэрт сонгогдсон аймаг, сумын иргэдийн дунд улс төрийн хошуучлалын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, тулгарч буй сорилт бэрхшээлийг тодорхойлох үүднээс социологийн судалгааны чанарын ярилцлагын аргаас Фокус бүлгийн ярилцлагын аргыг сонгон 5 аймгийн 5 сумд тус бүр 8 хүний бүрэлдэхүүнтэй нийт 40 хүнийг хамруулсан. Нэг удаагийн ФГЯ 1 цаг 20 минутаас дээш хугацаанд үргэлжилсэн. Тус хээрийн судалгааны мэдээллийг Улаанбаатар хотын 6 дүүрэг болон орон нутгийн босоо, хэвтээ тэнхлэгийн хүрээнд Ховд, Хөвсгөл, Баянхонгор, Өмнөговь, Сүхбаатар зэрэг аймгуудаас түүврийн хэмжээг тогтоосон. Үндсэн судалгаа 2023 оны 9 дүгээр сараас 11 дүгээр

сарын 20 хүртэл улс төр, эрх зүйн салбарын 5 гишүүн томилогдон ажилласан. Тоон судалгааг гүйцэтгэхдээ нийгэм-улс төрийн хөгжлийн талаарх мэдлэг, хандлага, үнэлэмж зэргийг үндсэн асуултуудын хүрээнд анкет-сурвалжилгын аргаар судалгааг судлаач биечлэн авсан юм. Мөн туршилтын судалгааг Ховд аймгийн Ховд сумаас 70 судалгаа авч дахин засварлалтыг оруулж сайжруулсны үндсэн дээр 2 дахь буюу үндсэн судалгааг явуулж гүйцэтгэсэн. Ийн социологийн тоон болон чанарын судалгааны нэгтгэсэн дүнд үндэслэн тус өгүүллийг бичиж байна. Тус судалгааны хүрээнд улс төр судлаач Р. Такерийн үзэл баримтлал хийгээд дэвшүүлсэн санааг тус өгүүлэлд баримталж байна. баримтлах болсон гол утга учир нь *«Улс төрийн үйл ажиллагаанд оролцдог хүн бүр засаглал эрх мэдэлд тэмүүлдэг»* талаар Макс Вебер онцлон хэлсэн нь ч бий. Нэг үгээр хэлбэл, *«Улс төрийн хошуучлал ямагт засаглал, эрх мэдэлд хүрэх эсхүл бусдад нөлөөлөх хүсэл эрмэлзлийн мөнхийн дагуул»* байдгийг Р.Такерын өгүүлснээс үзвэл, улс төрийн хошуучлал, засаглал, эрх мэдэл салшгүй холбоотой болохыг илтгэж буй хэрэг. (Хатанболд О, Баасансүрэн Д, Хишигдаваа А, ба бусад 2020, 157) хошуучлал гэж яригдах бүрд засаглал, эрх мэдэл, харилцаа байнга оршин тогтнох юм. Энэ нь Ж. Блондель болон Р.Такер нарын хошуучлалын тухай үзэл санаанаас харагдсан бөгөөд судалгааны үр дүнтэй яв цав таарч байна.

Хошуучлал нь бүлэг хүмүүс болон хувь хүн бүрд илэрдэг мөн эрх мэдэл анх төсөөлж байснаас илүүтэй тархсан байдаг нь уламжлалт шатлан

захирах бүтцээс гадуур хэрэгжиж болно. Ямартай ч хошуучлал нь улс төрийн орчинд хэрэгжиж, үзэгдэх болон үл үзэгдэх нөхцөлөөр сүлжээг бий болгож байна. Эдгээрийн шалтгаан нөхцөл нь улс төрийн хошуучлагчдын зөрчил, улс төрийн лидерийн хомсдол нэгэнт бий болсныг олон нийтийн санаа бодлын судалгааны дүнгүүд, улс төр судлаачдын сүүлийн үед хийсэн дүгнэлтүүдэд илрэх болсон. Улс төрийн хошуучлагч бол шинэчлэгч хошуучлагч (transformational leader) мөн, хоёр дахь үндэслэлийг харгалзвал, тэр нь солилцоонд үндэслэсэн хошуучлагч (transactional leader) улс төрийн хошуучлагчийн шинж чанарыг болон улс төрийн харилцаанд түүний үзүүлж буй нөлөөг, хошуучлалын нь хэв маягийг (эвлэрүүлэгч болон дайчлагч) судалж болох юм. Эерэг, сөрөг талуудыг тодруулах, өнөөгийн нөхцөл байдлыг үндэслэлтэй тодорхойлоход шинжилгээ хийж, харьцуулан судалж, бодит дүгнэлтийг гаргахад оршиж байгаа юм.

### III. Судалгааны үр дүн

Нийгэм аажмаар хувьсан өөрчлөгдөх бүрийд хошуучлагчид мөн адил төрсөөр байдаг. 1990-ээд оноос хойш манай нийгэмд томоохон өөрчлөлтүүд явагдаж эхэлсэн нь зарим талаараа улс орны эдийн засаг, гадаад харилцаа, улс төрийн харилцаанд ч ихээхэн нөлөө үзүүлсэн. Нийгэмд болж буй энэ үйл явдал бүрд түшиглэн хошуучлагчид төрөн гардаг бөгөөд тэднийг нэг нь удирдан манлайлж эхэлдэг. Энэ маягийн дагуу яван явсаар нийгмийн салбар бүрд удирдагчид төрөн гардаг хэмээн үзэж болох юм. Хошуучлагч нь нийгэмд болж буй үзэгдэл, үйл явдал, хувьсал,

өөрчлөлтөд үзүүлж буй нөлөө, гүйцэтгэх үүрэгтэй хэрхэн холбогдож буйг нийгмийн хөгжлийн онолд тулгуурлан тайлбарлах нь зүйтэй. Угтаа хөгжлийн онол бол нийгэмд хүссэн өөрчлөлтийг хэрхэн хамгийн сайн хэрэгжүүлэх тухай онолуудын үзэл санаа юм. Нэг ёсондоо аль онолыг судалж байгаагаас хамааран хөгжлийн үйл явц, тэдгээрийн тэгш бус байдлын талаарх янз бүрийн тайлбарууд байдаг авч дийлэнх нь эдүгээжилттэй (модернизаци) буюу “уламжлалт” эсвэл “хоцрогдсон” нийгмийг шинэчлэхэд хүргэдэг үйл явцтай холбодог. Анх модернизацийн зарчмыг дэвшүүлсэн францын соён гэгээрүүлэгч Маркиз дэ Кондорсе (1743-1794) хүмүүс өөрсдөө нийгмээ хөгжүүлж, өөрчилж чадна, технологийн дэвшил, эдийн засгийн өөрчлөлтүүд нь ёс суртахуун, соёлын үнэт зүйлсийг өөрчлөхөд хүргэдэг гэсэн дэвшлийн үзэл санаанаас харж болно хэмээсэн нь буй. Цаашлаад францын социологич Эмиль Дюркхайм нийгэм дэх институтийн харилцан хамаарал, тэдний соёл, нийгмийн нэгдмэл байдалтай харьцах арга хэлбэрийг онцлоход Дэвид Аптер, Сеймур Мартин Липсет нар улс төр (тухайлбал эдийн засгийн хөгжил нь ардчилалд хүргэдэг нийгмийн өөрчлөлтийг дагуулдаг), Дэвид Мак Клелланд сэтгэл зүйн сэдэлтэй, харин Талкот Парсонс орчин үеийн нийгмийн шинжийн хувьсалтай холбон тус тус тайлбарлаж ирсэн. (Чулуунбаатар Г, Хатанболд О, Железняков А.С., Цэцэнбилэг Ц, ба бусад 2023, 252, 253) Эдгээр онолын дагуу хөгжил нь эдийн засаг, нийгмийн өөрчлөлтүүдээс шууд шалтгаалдаг болохыг илтгэж байна. Ард олны амьдрал нийгмийн хөгжлөө дагаад сайжирдаг нь амьдралын жам

юм. Тэгэхээр нийгмийн өөрчлөлт нь эдийн засгийн хөгжлөө дагаад ард иргэдийн амьдрал ахуй сайжрах нь эерэг нийгмийн өөрчлөлтийг харуулж буй үйл явдал болж буй хэрэг мөн гэж үзэж болох юм. Иймээс нийгэм хөгжилд удирдагч, хошуучлагчийн үүрэг үр нөлөө онцгой их. Муу удирдагчийн нөлөөлөл их байх тус улс орон болон ард иргэдийн соёл, уламжлал, сэтгэхүйгээр уналтад орно гэж үзсэн байна. Ялангуяа энэ нь сүүлийн жилүүдэд сошиал орчинд олон дагагчтай нөлөөлөгчдийг тооцон үздэг болсон бөгөөд нэр хүнд муутай инфлюэнсэрүүд нийгэмд буруу үлгэр дуурайлал үзүүлж, буруу хандлага руу хөтөлдөг гэж иргэд их эмээх болжээ. Иймд буруу үлгэр дуурайлалтай, буруу ойлголтод хүргэдэг хүний сошиал хаягийг нь дагахгүй, лайв видеог нь үзэж хандалтын тоог нь нэмэхгүй байх зэрэг арга хэмжээ авах нь иргэн хүний ухамсарлан ойлгох

бас нэг арга байж болох юм. Төр нь ард түмнээсээ тасарч, цаашлаад ард түмэнтэйгээ хамтарч хийгээгүй аливаа өөрчлөлт нийгмийн гишүүдийг сэтгэл дундуур болгон үлдээж, шинэ нөхцөлд зөв зохицох (адаптаци) чадварыг нь алдагдуулж, маргаашдаа итгэх итгэлийг нь бууруулж, олон нийтийн дунд хардалт, сэрдэлт, бухимдлыг буй болгодог гэдгийг эдүгээгийн монголчууд бидний амьдрал ч бэлхнээ харуулж байна. Манай нийгэмд янз бүрийн салбарт ухамсартай хийгдэх өөрчлөлт янз янзын цар хүрээтэйгээр цаашид ч өрнөх болно. Иймээс алдаж онож байгаад хүрсэн үр дүнгээ эргэн харж, түүндээ шинжилгээ хийх замаар цаашдын зорилтоо тодорхойлж төлөвлөх нь чухал юм. (ФСЭЗХ 2013, 20) Алдаанаасаа суралцаж шинэ рүү тэмүүлж, ард иргэдийн хүлээлтэд нийцсэн нийгмийг бүтээх нь магадгүй хошуучлагч бүрийн санаа зовнилуудын нэг болсон биз ээ.

Зураг 1. Улс төрийн хошуучлалын ойлголтыг илэрхийлэх дүрслэл



Өгүүлэн буй сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн судалгааны асуулгаар иргэдийн улс төрийн хошуучлалын ойлголтын ерөнхий дүр зургийг

гаргахад: улс төрийн хошуучлагч нь багийн ажиллагаа (30.4%) хийгээд хамтын хүч хөдөлмөрийн оролцоотой байхыг илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл,

ард түмний сонголт, дэмжлэгээр болон сонгуулиар ялалт байгуулан сонгогдсон (29.8%) хүнийг улс төрийн хошуучлагч гэж ойлгож байна. Нөгөөтээгүүр бусдыг байлдан дагуулах шинж чанартай чиглүүлэгч ба аливаа байгууллага, олон нийтийг удирддаг хэн нэгнийг удирдагч хэмээн үзэх хандлага нийтлэг (23.0%). Түүнчлэн хөрөнгө мөнгөтэй, залгамж халаагаар (16.7%) гарч ирдэг гэж ойлгох иргэд энэ бүлэгт нь хамрагдаж байна. Манлайлагчийн ололт амжилт, гүйцэтгэх үүрэг ролийн хувьд өмнөх

үе буюу түүхэн үйл явцтай салшгүй холбоотой бөгөөд орчин үед шинэ технологийн арга хэрэгслүүд, шинэ зарчмууд болон туршлагад суурилсан механизмаар тодорхойлогддог. Ийм учраас улс төрийн тавцанд чухал үүрэгтэй төдийгүй гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа, хамрах хүрээ, үр дагавар нь олон янз байна. Нийгмийн хувьсал шинэчлэл бүрд тодорхой удирдагчид төрөн гардаг нь бидний амьдарч буй бүх үеийн туршлагад хийгээд олон эрдэмтэн судлаачдын нотолсон үзэл баримтлалаар илрэн гарч ирдэг.

Зураг 2. Улс төрийн хошуучлагч бий болоход нөлөөлж буй хүчин зүйлс (хувиар)



Улс төрийн хошуучлагч болоход ард түмний сонголт хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг ба тухайн удирдагчийн өөрийн мэдлэг чадвар ч мөн адил чухал. Мөн эрх мэдэл хийгээд хөрөнгө, мөнгө ч тодорхой хэмжээгээр нөлөөлдөг болох нь иргэдийн дунд нийтлэг байдаг. Ямар нэг байдлаар олны дунд нэр хүндтэй болж бусдад хүлээн зөвшөөрөгдөх явдал дундаж байдлаар нөлөөлөхийн зэрэгцээ намын залгамж халаагаар бэлтгэгдэх тохиолдол ч бас чухал ач холбогдолтойг энд тэмдэглэмээр байна. Дээрх бүгдээс хошуучлалын эрх мэдэл үүсэж байгааг

харж байна. Хэдийгээр ард түмний сонголт, өөрийн мэдлэг ур чадварын хүрээнд сонгогдсон болов ч, энэ бүхэн нь эрх мэдлийн төлөө эсвэл эрх мэдлийг ч олгож болох талтай юм. Яг энэ асуултын хүрээнд онолын хүрээнд тайлбарлавал: засаглал, эрх мэдлийн харилцааны шинж чанар нь түүнд оролцож буй үндсэн субъект болох улс төрийн хошуучлалын идэвх оролцоо, гүйцэтгэж буй үүрэг түүнд үзүүлж буй нөлөө зэргээс шууд хамааралтайг илтгэнэ. Өрнөдийн томоохон судлаачид улс төрийн хошуучлал хийгээд засаглал, эрх мэдлийн

асуудал нягт уялдаа холбоотой, харилцан шүтэлцээтэй болохыг онцлон тэмдэглэсэн нь бий. Үүний нэг нь францын нэрт улс төр судлаач Ж.Блондель “Улс төрийн хошуучлал угтаа засаглалын үзэгдэл юм” хэмээн тодорхойлсон байх ба тэрээр «Эрх мэдлийн оргилд хүрсэн нэгэн (эхсүл хэсэг бүлэг хүмүүс)-ээс бусдыг эерэг ба сөрөг үйлдэл хийлгэх ур чадварын хувьд хошуучлал бол засаглал» хэмээсэн байдаг. Нэг талаараа засаглал хошуучлалыг бүрдүүлэгч гол хэсэг бол улс төрийн эрх мэдэл нийгмийн гишүүдийг үйл хийлгэхийн тулд оршдог гэж үзсэнээс илт харагддаг.

Түүнчлэн энэ тухайд 3. Лхагвадоржийн улс төрийн шинжлэх ухааны докторын (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээлд “Улс төрийн засаглал нь хошуучлагчийн эрх мэдлийн асуудалтай шууд буюу дам холбогдсон байдаг бөгөөд эрх мэдлийн аливаа үйлдэл, бүрэн эрх нь тодорхой хүн-улс төрийн хошуучлагчаар дамжин” хэрэгждэг талаар тэмдэглэсэн

байна. Тэрээр цааш нь тэмдэглэхдээ: “нийгэмд улс төрийн механизмыг хэрэгжүүлэгч бодит мөн чанарыг улс төрийн хошуучлал өргөн хэмжээнд тодорхойлдог бөгөөд орчин үед олон нийтийн санаа бодолд тулгуурлан түүнийг эергээр буюу хошуучлагчийн нэр хүндийг өргөх зорилгоор бүрэлдүүлэн төлөвшүүлэхэд улс төрийн коммуникацийн үүрэг нөлөө улам өссөөр байгаа. (Лхагвадорж 3 2015, 21) талаар дэлгэрэнгүй дурдсан байдаг. Энэ байдлаар улс төрийн хошуучлалыг болон хошуучлагчдын үүргийг олон судлаач, докторууд судалж буй хэдий ч шинжлэх ухааны эргэлтэд оруулах хэмжээний нарийн судлагдаагүйгээс гадна иргэд олон нийтийн мэдлэг хангалтгүй байгаад гол асуудал оршиж байгаа юм. Тиймээс “Хошуучлал” гэх нэр томъёог шинжлэх ухаанд оруулахын зэрэгцээ уг үгийг мэддэг, хэрэглэдэг болгоход ач холбогдол өгөх нь зохистой арга хэмжээнүүдийн нэг болж байна.

*Хүснэгт 1. Нийгэмд эерэг болон сөрөг талаараа танигдсан улс төрчид*

| №  | Нийгэмд эергээр нөлөөлж буй улс төрчид | Хувь | Нийгэмд сөргөөр нөлөөлж буй улс төрчид | Хувь |
|----|--|------|--|------|
| 1  | Л.Оюун-эрдэнэ                          | 8.3  | УИХ-ын бүх гишүүд (улс төрчид)         | 15.0 |
| 2  | Н.Учрал                                | 5.5  | Х.Нямбаатар                            | 9.2  |
| 3  | У.Хүрэлсүх                             | 3.7  | Д.Сумьяабазар                          | 6.1  |
| 4  | Д.Мөнх-Эрдэнэ                          | 3.5  | У.Хүрэлсүх                             | 4.3  |
| 5  | С.Ганбаатар                            | 2.2  | Ц.Элбэгдорж                            | 3.8  |
| 6  | Х.Баттулга                             | 2.1  | Л.Оюун-Эрдэнэ                          | 2.2  |
| 7  | Л.Энх-Амгалан                          | 1.5  | Сү.Батболд                             | 1.9  |
| 8  | Н.Энхбаяр                              | 1.3  | Б.Чойжилсүрэн                          | 1.5  |
| 9  | Бусад                                  | 20.3 | Ж.Ганбаатар                            | 1.5  |
| 10 | Байхгүй                                | 51.6 | Ц.Нямдорж                              | 1.3  |
| 11 | -                                      | -    | Бусад                                  | 18.9 |
| 12 | -                                      | -    | Байхгүй                                | 34.3 |

*Тайлбар: (Үр дүнд тооцогдохгүй 0.1%-1.2%-ыг бусад руу нэгтгэв.)*



Дээрх хүснэгтийн асуулгаар Монгол Улсад эергээр болон сөргөөр нөлөөлж буй хошуучлагчийг нэрлэж болохоос гадна илүү манлайлалтай гишүүнийг мөн харуулж буй. Сүүлийн үед улс төрд гарч ирсэн залуу улстөрчдийг иргэд яагаад нийгэмд эергээр нөлөөлөгч хошуучлагч гэж харж байгааг иргэдээс авсан чанарын шинжилгээний дүнгийн хэсгээс дүгнэн үзэхэд дараах байр суурь нийтлэг ажиглагдлаа. *Нэгдүгээрт «Улс төрч гэдэг утгаар нь сонголоо. Харвардын их сургууль төгссөн, басхүү үзэл бодлоороо ард түмэнтэйгээ нэгдэж чаддаг санагддаг. Жагсаал хүртэл зохион байгуулж иргэдээ төлөөлж, өмнөөс нь дуу хоолойг минь сонсож цааш нь дамжуулж байсан зэрэг нь залуу хүн гэхэд зоригтой санагдсан»* гэдэг тайлбар өгсөн. *Хоёрдугаарт* Н.Учралын хувьд *«Цахим хөгжлийн яамыг удирдах болсноор мэдээлэл цахимжиж, улмаар нийгмийн хөгжлийг дагаад цахимжиж байгаа нь сайн хэрэг. Гишүүнийхээ хүрээнд ч мөн адил их сайн ажиллаж байгаагаас гадна дөнгөж байгуулагдсан яамыг маш сайн удирдаж чадсан хүн. Ер нь удирдах арга барил, гүйлгээ ухаан их сайтай, дээр нь эх оронч сэтгэлтэй санагддаг гэсэн үзэл бодлоор иргэд түүнд эергээр ханддаг болохоо илэрхийлсэн байна. Гуравдугаарт «У.Хүрэлсүх ерөнхийлөгч бол ард түмний эв нэгдлийн төлөө шударга ёсыг баримтлаад нэлээн хүчтэй дуу хоолойгоо илэрхийлж гарч ирсэн. Улс төрд бас хүчтэй, тууштай, зоригтой манлайлагч хүн байх хэрэгтэй байдаг»* хэмээн чанарын шинжилгээнд хамрагдсан иргэд өөрсдийн үзэл бодлоо ийнхүү нээлттэй илэрхийлсэн байна. Дээрх хүснэгтэд нэр дурдагдсан бусад хүмүүсийн хувьд Д.Мөнх-

Эрдэнэ, С.Ганбаатар, Х.Баттулга, Л.Энх-Амгалан нарыг багтаасан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд нийгэмд эергээр нөлөөлдөг улс төрч гэдэгт хангалттай буюу сэтгэлд нь нийцсэн улс төрч байхгүй хэмээн үзсэнтэй холбоотой юм.

#### IV. Хэлэлцүүлэг

Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд нийгэмд эергээр нөлөөдөг, нэр хүндтэй улс төрч хэмээн үзэх иргэдийн төсөөлөл харьцангуй суларсан нь улс төрийн хүрээн дэх авлига, хээл хахууль, шударга бус үйл ажиллагаа зэрэг өнөөгийн монголын нийгмийн харилцаанд тулгарч буй аливаа асуудлыг шийдвэрлэхэд хангалттай хэмжээний хариуцлага, идэвх санаачилга гаргахгүй байгаа зэргээр улбаатайгаар ийнхүү асуулгад *“Эергээр нөлөөлөх улс төрч үгүй”* хэмээн хариулахад хүргэсэн байх магадлал өндөр байгааг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй болов уу. Энэ бүхнээс “шилдэг” нь болж хошуучлах улс төрч байхгүй болохыг ийнхүү судалгааны дүнгээр нотлон харуулж байна.

Улс төрийн хошуучлагчийн сэтгэлгээний шинж чанар нь нэгтгэсэн ойлголт байдаг хэмээн үзвэл, үүнд сэтгэлгээний уян хатан зан байдал, бүтээлч, хурдан шуурхай чанар аливаа асуудлыг олон талаас нь задлан шинжлэх зэрэг тодорхой чанаруудыг эхлээд ярих хэрэгтэй. (Ганхуяг Д. 2004, 56) байдаг. Үүнийг дараах байдлаар дэлгэрүүлэн үзвэл:

2020 онд “Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага” сэдэвт олон нийтийн санаа бодлын судалгаагаар *“Та хэнийг хамгийн*

том лидер гэж бодож байна” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 46.1 хувь нь “лидер байхгүй” (Ганхуяг Д. 2004, 157) гэж хариулсан хэдий ч тэдний дөнгөж 6.1 хувь нь ерөнхийлөгч асан Х.Баттулгыг нэрлэж байжээ. Харин 2024 онд хийгдсэн судалгаагаар дээрх асуултыг давтан асуухад судалгаанд хамрагдсан иргэдийн 51.6 хувь нь “лидер байхгүй” гэж хариулсан өмнөх судалгаан дүнгээс 5.5 хувиар “итгэлгүй” хариулт нэмэгдсэн харамсалтай дүн гарчээ. Үүнээс дүгнэвэл, өнөөгийн монголын нийгэмд сөргөөр нөлөөлж буй улс төрчид байхгүй гэж үзэх иргэд дийлэнх массыг эзэлсэн нь дээрх хүснэгтээс харагдаж буй. Иргэдийн хувьд улс төрд, улс төрчдөд итгэх итгэл суларсантай холбоотой үзэж болохыг илтгэж байна.

Улс төрийн хошуучлагчийн чухалд тооцогдож буй нийгмийн гарлын хүчин зүйлсэд **насны** хувьд 41-50 насны (35.2%), **шашин шүтлэгийн** хувьд будда (45.7%), **мэргэжлийн** хувьд эдийн засагч (26.3%), **үндэс угсааны** хувьд халх (55.4%), **хүйсийн** хувьд эрэгтэй (65.0%) байх нь чухал ач холбогдолтой болохыг хамаарлын шинжилгээ харуулж байна. Түүнчлэн улс төрийн хошуучлагчийн гадаад төрхийн хувьд олон нийттэй харилцах, өөрийгөө илэрхийлж буй байдлыг нэлээд чухалчилдаг (52.1%), өөртөө итгэлтэй байдлыг (29.5%), бусдад сэтгэгдэл төрүүлэхүйц байдал (22.8%), ярих, илтгэх чадвар (19.3%) зэргийг иргэд голлон анхаардаг байна. Харин хошуучлагч хүнд заавал байх үндсэн шинжүүдийг олон сонголттой асуулгын хүрээнд иргэд дараах байдлаар хариултыг өгсөн.

Үүнд: шударга, зарчимч (56.5%), хариуцлагатай (40.5%), ёс зүйтэй (38.2%), эх оронч сэтгэлгээтэй (34.2%), нийтийн эрх ашгийг хамгаалдаг (32.4%), өөрийгөө болон бусдыг хүндэтгэдэг (28.7%), зорилгодоо хүрэх хүсэл тэмүүлэлтэй (26.0), үндэсний үзэлтэй (18.7%), зөрчил сөргөлдөөнийг зохицуулах чадвар (16.3%), шинийг эрэлхийлэгч (15.8%), улс төрд өөрийн гэсэн дүр төрхийг бүрдүүлсэн (12.4%), шийдэмгий бөгөөд тууштай (14.8%), уян хатан (7.1%), хошин шогийн мэдрэмжтэй (1.5%), бусад (1.1%), хэлж мэдэхгүй (3.1%) ийнхүү давхардсан байдлаар тус тус хариулсан байна. Үүнээс харахад иргэдийн хувьд хошуучлагч хүнд байх ёстой хамгийн чухал шинж бол шударга, зарчимч шинж чанар, хариуцлагатай, ёс зүйтэй, эх оронч төдийгүй нийтийн эрх ашгийг хамгаалдаг байхыг нэн тэргүүнд чухалчил байгааг судалгааны дүн бэлхнээ хариулж байна. Тоон судалгааны эл нөхцөл байдлыг чанарын шинжилгээгээр батлахын зориход мөн л дараах байр суурийг түлхүү илэрхийлсэн байна. Тухайлбал, *Шударга, зарчимч гээд нөгөө хэдэн жишүүрийн мэт санагдах шинжүүд заавал байх ёстойгоос гадна бүтээлч, шинийг эрэлхийлэгч, аливаад бэрхшээлтэй асуудлыг олж хараад шийдвэрлэдэг, басхүү эх оронч сэтгэлгээтэй байхыг нэн тэргүүний зарчим хэмээн үзэж байна. Цаашлаад хошуучлагч хүнд хамгийн чухал шинж чанарын бас нэгэн чухал зүйл багийн ажиллагаа аж. Нэг үгээр ард түмнээ энэрэх, ард түмэн нь бас хошуучлагчаа гэж хүлээн зөвшөөрдөг, басхүү үндэсний үзэлтэй байх ёстой гэдэг*

дээр нийтлэг байдлаар нэгдэж байна. Энэ бол ард түмнийхээ болоод багийн гишүүдийнхээ үгийг сонсдог, аливаа санал, шүүмжлэлийг хүлээн авах чадвартай, буруутай бол хариуцлага хүлээх ёс зүйтэй байхыг шаардаж байгааг чанарын шинжилгээний үр дүн тодорхой илтгэж байна.

Иргэдийн дунд хошуучлагчдын итгэл үнэмшил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үзэл зэргийг илүүтэй чухалчилдгаас гадна сул итгэл үнэмшилтэй улс төрийн хошуучлагчид (гэхдээ л үндэсний үзэл нь байж байгаа) бас эх орончид байдаг бөгөөд тэд эх орноо үл хамаарах бие даасан байлгахыг хүсдэг нь үүнтэй холбоотой байж болох юм. Гэхдээ тэд ертөнцийг хар цагаанаар харах бэлтгэл бага, үндэстний төвч үзэл нь харьцангуй бага байгаа нь үүнээс илт байна. Нөгөөтээгүүр хүмүүсийг “өөрийн”, “хүний” гэж хуваах боловч энэ нь нэгд, нөхцөл байдал хийгээд нийгэмд

тулгарч буй тухайн бэрхшээл саадаас хамааралтайг харуулаад зогсохгүй тэдний энэ ойлголт нь улс оронд тухайн үед юу болж байгаагаас хамааран их хөдөлгөөнтэй байдаг. (Ганхуяг Д. 2004, 51) болохыг анхааралдаа авч үзэхийг чухалчилж байна.

Улс төр судлаач Роберт Такерийн хошуучлалын талаар тодорхойлсон дээрх гурван хэв маягийн аль нь өнөөгийн нийгэмд зонхилж байгааг тус өгүүллээр тодруулан гаргахыг зорьсон юм. Чингэхдээ чанарын ярилцлагад хураангуй байдлаар шинжилгээ хийж үзэхэд дараах гурван санаа хамгийн нийтлэг илэрхийлэгдсэн юм. *Нэгд, соёлтой байх, залуу эрч хүчтэй байх, Улс орны эдийн засаг, улс төрийн болон сонгуулийн системийг бүхлээр нь өөрчилж чадах хүн байх нь юу юунаас илүү чухлаар тавигдаж байна. Хоёрт, үзэл бодолдоо үнэнч, зарчимч байх шаардлагатай.*

Зураг 3. Роберт Такерын улс төрийн хошуучлагчдын 3 хэв маяг



Нэг ёсондоо аливаа ажлыг эхлүүлсэн бол түүнийгээ хариуцлагатай, ёс зүйтэй, төгс гүйцэтгэлтэй дуусгадаг байх. Цаашлаад аливаад хэт нэгийг талыг баримталсан туйлшрамтгай, нам төвтэй байх нь зохимжгүй. Бүх

зүйлд шинэ үзэл бодлоор ханддаг, хувийн эрх ашгаас ангид, авлига, хээл хахуулиас татгалзах ёс зүйн ухамсартай, улс эх орны эдийн засаг хийгээд бусад уналттай байгаа салбаруудыг шинэчлэн хөгжүүлэх

замаар шинэ системийг дайчлан оруулж ирэх зоригтой байх ёстой. Гуравд, улс орныхоо хөгжлийг нэн тэргүүнд тавьдаг, гадаад харилцаандаа анхаардаг, шударга байдлыг эрхэмлэдэг байхыг чухалчилсан байхыг шаардаж байна. Энэ нь Р.Такерын дэвшүүлсэн уламжлалаа ойлгож, мэдэрдэг, шинэчлэлийг эрэлхийлдэг, нийгмийн шилжилтийг цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах, бүтээх чинхүү зоригтой гурван хэмжээст шинжийг өөртөө агуулсан улс төрийн хошуучлагч ирээдүйн улс төрийн манлайллыг түүчээлэх учиртай аж. Нэг үгээр бол улс төрийн хошуучлагчийн шийдвэр гаргах арга барилд багтсан догматизмтай байхыг илтгэж байна. Догматик улс төрийн шинэ хошуучлагчид шинэ мэдээ мэдээлэл хүлээн авах, шийдвэр гаргахад нь уламжлал, зарчим нэн чухал байдаг. Р.Ваккианны болон түүний хамтрагсад догматик хүн *“хуучинсаг, тогтсон үзэл санааг хүндэтгэдэг”* гэж тэмдэглэсэн нь бий. Тэрээр улс төрийн чиг баримжааг өөрчлөхийг хүсдэггүй бөгөөд үүнийгээ өөрийнхөө үйл ажиллагааг улс орны бүх юмны уламжлалт, цуглуулга мэт үздэг. (Ганхуяг Д. 2004, 157) хэт баригдмал үзэл баримтлалд байнгын шинэ “салхи” хандлагыг бий болгож байх нь нэн чухал болох нь судалгаан үр дүнгээс багцлан үзэж болохоор байна. Манай улсад бидний хошуучлагч гэж үзэх улс төрчид иргэдийн итгэлийг алддаг, нэр хүнд муутай, алгуур сууж хойшилдог консерватив байр сууринаас ханддаг хошуучлагчид давамгайл байна. Иймд иргэд хуучин үзлээ халж шинэ соёл руу нэвтрэхдээ хошуучлагчдыг ч

мөн адил реформ хийж хийж шинэ сэргэлтийг авчран улс орныг хөгжил рүү түлхсэн удирдагч хошуучлагчид болж хувирах нь ард түмний сэтгэлд нийцэхээр байна.

## V. Дүгнэлт:

Эл өгүүллийн хүрээнд иргэд олон нийтээс хошуучлалын талаарх төсөөлөл, мэдлэг, хандлага, ойлголтын талаарх олон нийтийн санаа бодлын практик судалгаа явуулсны үр дүнд болон онол арга зүйд үндэслэж байна. тус сэдвийн хүрээнд тоон буюу анкет-сурвалжилгын аргаар 52 асуулгын хүрээнд ерөнхий мэдээлэл, мэдээллийн төрөл, эх сурвалж, улс төрийн сонирхол, оролцоо, хошуучлалын талаарх мэдлэг, ойлголт, улс төрийн хошуучлалын тухай гэсэн нийт 5 бүлэг асуултаар иргэдийн санаа бодлыг тандсан судалгаа хийв. Судалгааны онол арга зүйн хүрээнд олон эрдэмтэн, судлаач нарын үзэл баримтлалаас Р.Такер болон Ж.Блондель нарын улс төрийн хошуучлагчдын тухайлан үзсэн үзэл санаанд тулгуурлав. Энэ нь судалгааны хошуучлагчдын хэв маяг хийгээд, тодорхойлсон тодорхойлолтуудтай яв цав таарч байна хэмээн судлаачийн хувьд үзэж байна. Судалгаа ба Р.Такер болон Ж.Блондель нарын онол үзэл баримтлалтай хэрхэн нийцэж буй талаар энэ хэсэгт дүгнэн оруулав. Үүнд: Тэрээр хошуучлал ямагт засаглал, эрх мэдлийг дагуулдаг хэмээн үзсэн. Судалгааны дүнгээр эрх мэдэл хийгээд нэр хүнд, нийгмийн давхраа, хөрөнгө мөнгөтэй холбогддог, нөгөө талаас эдгээрийг залгамж халаагаар авдаг тухай иргэд өөрсдийн байр сууриа илэрхийлж

байв. Улс төрийн албанд зүтгэж байгаа тохиолдолд нэр төр, алдар хүнд, эд баялаг, албан тушаал зэрэг нь яригдахаас өөр аргагүй байдаг. Улс төрийн хошуучлалд нас, хүйс, мэдлэг боловсрол, мэргэжил, үндэс угсаа, шашин гээд нийгмийн байр суурь нь хамгийн чухал бөгөөд эдгээрийг хүссэн хүсээгүй олж авдаг. Мөнхүү хошуучлалыг иргэд бас өөр нэг утгаар илэрхийлж буй нь Улс төрд хошуучлал нь залгамж халаагаар бэлтгэгддэг бөгөөд цүнх баригчаас эхэлдэг тухай иргэд ярилцлагадаа олон удаа хэлж байв. Цүнх баригч нь намын залгамж халааг авах бэлтгэл нь болж буйг дурдсан бөгөөд улс төрд хамгийн бага албан тушаалтан буюу цүнх баригчаас ч эхэлнэ гэсэн байр сууринаас санаа бодлоо илэрхийлж байв. Юуны өмнө хошуучлал нь эх оронч сэтгэлгээтэй байхыг хэн хүнгүй хүсдэг байна. Иргэд, олон нийт эх оронч, үндсэрхэг үзлийг чухалд тооцдог боловч тэр нь харьцангуй сул байна. Хошуучлагч нь өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаг, шударга зарчимч, хариуцлага өндөртэй, илүү экстраверт бүхий хошуучлагчийг хүсдэг. Энэ агуулгаараа дээр дурдсан чадваруудыг өөртөө шингээсэн аливаа асуудлыг олж боловсруулах чадвар сайтай, бусдад нэр хүндтэй, багийн ажиллагаагаар манлайлахыг өнөөгийн цаг үе, нийгмийн амьдрал шаардаж байна.

Үүний зэрэгцээ хатуу бөгөөд дайчин шинж чанарыг эрхэмлэдэг *тугч, ухуулагч, үйлчлэгч, гал унтраагч* гээд хошуучлагчийн имиж бүрдүүлэлтийн бүх хэв маягийг агуулсан хүнийг өнөөгийн монголчууд нийтлэгээр хүсдэг гэвэл бас хэт

өрөөсгөл дүгнэлт болно. Тэгэхээр олон нийтийн хувьд үйлчлэгч хэв маягийн хошуучлагчийг хүсдэг болох нь санаа бодлын судалгааны үр дүнг боловсруулах явцад илэрхий байгаа нь ажиглагдсан. Энэхүү судалгааны явцад хошуучлагч нь бие хүний өөрийн зан байдал мөн нийгмийн социаль шинж чанар буюу нийгмийн байр суурь/ өөрийнх нь эд баялаг, гарал үүсэл, нэр алдар/ цаашлаад хошуучлалын бүлгүүд хоорондын харилцаа нь хошуучлагч бий болоход нөлөөлдөг магадлалтайг бэлхнээ илтгэж байна.

Олон нийтийн санаа бодлын судалгааны дүнгээс ч өнөөгийн монголын нийгэмд хошуучлал нь идэвхтэй байр сууринаас хандахыг хичээдэг басхүү хуучин буюу уламжлалт байр сууриа хадгалж түүнийгээ хуримтлуулсан туршлага болгон үлдээж гэмээ нь орчин цагийн өнгө аяс руу нэвтрэх реформист буюу шинэчлэгч байр сууринаас хандсан маягтай байх хандлага монголчуудын дунд нийтлэг байсаар буй хэмээн судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэж байна. Нийгэмд улс төрийн хошуучлал гэдэг үгний хамтаар болон түүний гүйцэтгэх үүрэг болон олон нийтэд ач холбогдлыг нь тайлбарлан хүргэж соён гэгээрүүлэх ажилд оролцох нь том алхмуудын нэг гэж харж байна.

### **Талархал**

Энэхүү өгүүллийг Монгол Улсын Боловсрол, Шинжлэх ухааны яамны захиалга, ШУТС-ийн санхүүжилтээр ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр эрх зүйн салбарт 2022-2024 онд хэрэгжиж буй “Улс төрийн харилцаанд улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө” (ШУТБИХХЗГ-2022/191) сэдэвт суурь судалгааны төслийн үр

дүнд тулгуурлан бэлтгэв. Өгүүллийг монголын улс төр, нийгмийн онцлог үйл явдал хийгээд хошуучлагчийн нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, үр нөлөө социологийн судалгаанд тулгуурлан гүйцэтгэхэд онол, арга зүй, аргачлалыг боловсруулсан эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,

доктор (Ph.D) О.Хатанболд, улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор А.Цанжид нарт болон дээрх өгүүллийн санааг арвижуулахад зөвлөн, дэмжлэг үзүүлсэн салбарын хамт олондоо талархаж байна.

### Ашигласан материал

Цэвэл Я. 1966. Монгол хэлний тайлбар толь. ред. Х. Лувсанбалдан., 331, 702. Улаанбаатар: ШУА, ХЗХ. Улсын Хэвлэлийн Хэрэг Эрхлэх Хороо. Нэвтэрсэн 2024 оны 08 28. «Монгол хэлний тайлбар толь». <https://toli.query.mn/static/preface-tsevel>.

Баярсайхан Б. 2011. Монгол хэлний тайлбар толь. ред. Янжиндолгор А, 684, 1489. Улаанбаатар: “Монсудар” хэвлэлийн газар.

Отгонбаяр Н. 2019. *Манлайлал ба сэдэлжүүлэлт*. 09 10. <https://monleadership.blogspot.com/2019/09/blog-post.html>.

ХЗХ., ШУА. 2008. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. 20. Улаанбаатар.

Наранцэцэг П. 2020. *Улс төрийн боловсролын академи*. Vers. №18, 1997. 03 04. <https://academy.edu.mn/2020/03/04/>.

Хатанболд О., Баасансүрэн Д., Хишигдаваа А., ба бусад. 2020. Монгол дахь улс төрийн соёл; уламжлал, орчин үе. ред. Баасансүрэн Д., Хатанболд О. 157. Улаанбаатар: ШУА, Философийн хүрээлэн, “Соёмбо принтинг” ХХК.

Чулуунбаатар Г., Хатанболд О., Железняков А.С., Цэцэнбилэг Ц, ба бусад. 2023. Евроазийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёл иргэншлийн харилцан үйлчлэл. ред. Хатанболд О., Железняков А.С., Чулуунбаатар Г, 252-253. Улаанбаатар: ШУА-ийн Философийн хүрээлэн, “Соёмбо принтинг” ХХК.

ФСЭЗХ. 2013. Монголын нийгмийн өөрчлөлт. ред. Чулуунбаатар Г, Даш-Ёндон Б, 20. Улаанбаатар: ФСЭЗХ, ШУА, “Бэмби сан” хэвлэлийн газар.

Лхагвадорж З. 2015. “Улс төрийн хошуучлалын имиж бүрдүүлэлтийг судлах онол арга зүйн асуудал /Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулиудад нэр дэвшигчдийн жишээн дээр/. Улаанбаатар. 21.

Ганхуяг Д. 2004. Хошуучлагчийн улс төрийн имиж, түүнийг бүрдүүлэхүй. 157. Улаанбаатар: “Бэмби сан” хэвлэлийн газар.